

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна.							
1.1.1	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	-	Онлайн сүлжээнд холбосон сумдын тоо;	10 сум улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон.	Холбогдоогүй нийт 3 сумдыг онлайн сүлжээнд холбосон байна.	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй Дашбалбар, Халхгол, Чулуунхороот сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбосон.	
1.1.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног	-	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо;	2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 57 засвар үйлчилгээг хийсэн.	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 23 удаагийн засвар үйлчилгээг хийж техник, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг	

	төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах					ханган ажилласан.	
1.1.3	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох	-	Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоо;	Нэг цэгийн үйлчилгээ 8110, E mongolia-аар улсын бүртгэлийн 21 лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн.	Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна.	E mongolia-аар 135 иргэнд улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн.	
1.1.4	Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	2020 онд И-баримт-аар 832 иргэн, Пост терминал төлбөрийн машинаар 905 иргэн үйлчилгээ авсан.	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Пост терминал төлбөрийн машинаар 146 иргэн үйлчилгээ авсан байна. Үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын мэдээллийн самбар, www.dornod.burtgel.gov.mn цахим сайт, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол сурталчилж ажиллав.	
ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.							
2.2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Бүртгэлийн тоо;	Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 17355, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6226, хуулийн этгээдийн	

				чиглэлээр 1079, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 7830 бүртгэл хийгдсэн.		улсын бүртгэлийн чиглэлээр 910, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4412 бүртгэл хийгдсэн.	
2.2.2	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо; -Олгосон гэрчилгээний тоо;	2020 оны жилийн эцэст гадны аймаг нийслэлийн харьяа 6ш салбар төлөөлөгчийн газар бүртгэж, 6ш гэрчилгээ олгосон.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ.	2021 оны эхний хагас жилийн байдлаар өөр аймаг, нийслэлийн харьяа 2ш салбар төлөөлөгчийн газар бүртгэж, 2 ш гэрчилгээ олгосон. Дорнод аймагт бүртгэлтэй 1 салбарт нэмэлт өөрчлөлт оруулсан байна.	
2.2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;	2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 4199, хууль хяналтын байгууллагад 630 иргэний лавлагаа, мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 205, хууль хяналтын байгууллагад 26 хуулийн этгээдийн лавлагаа, мэдээлэл,	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 1021, албан хэрэгцээнд 183, хууль хяналтын байгууллагад 142 иргэний лавлагаа, мэдээллийг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 24, хууль хяналтын байгууллагад 13 хуулийн этгээдийн лавлагаа, мэдээлэл, Эд хөрөнгийн эрхийн улсын	

				<p>эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 682 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 281 албан бичгээр лавлагаа тус тус олгосон.</p>		<p>бүртгэлийн мэдээллийн сангаас 303 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 110 албан бичгээр лавлагаа тус тус олгосон.</p> <p>Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 8 албан бичгээр 10 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж, эрх сэргээх тухай 10 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 14 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээсэн.</p> <p>Монголын ипотекийн корпорацаас тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн 4 банкны 46 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж ажилласан.</p>	
2.2.4	Санхүүгийн тайланг		-Санхүүгийн	2020 оны жилийн	Улсын бүртгэлээс	2021 оны эхний хагас	

	<p>найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах</p>		<p>тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээх; - Баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах; -Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах; -Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах;</p>	<p>эцсийн байдлаар 26 хуулийн этгээд татан буугдсан байна.</p>	<p>хасагдах хуулийн этгээдийг байгууллагын цахим хуудсаар нийтэд зарласан байна.</p> <p>Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.</p>	<p>жилийн байдлаар 8 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасч татан буулган, хувийн хэргийг хэлтсийн архивт шилжүүлээд байна.</p>	
2.2.5	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх;</p>	-	<p>-Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах; -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн</p>	-	<p>Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Баяндун суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангаж, хүн ам болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн тоон судалгааг гаргаж УБЕГазарт хүргүүлэв.</p>	

			үйлчилгээг суманд үзүүлж эхлэх;				
2.2.6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	-Гэрээний хэрэгжилтийн хувь;	“ХААН даатгал” ХХК-тай хамтарч бүртгэгч нарын хариуцлагын даатгал хийгдэж эхэлсэн.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч, 3-н улсын бүртгэгч нарыг “ХААН даатгал” ХХК-н хариуцлагын даатгалд хамруулсан. Мөн “ХААН даатгал” ХХК-н зохион байгуулсан хариуцлагын даатгалд даатгах талаар сургалтанд хамруулж ажилласан.	
Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.							
2.3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд төлөвлөгөөт 3, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 6 хяналт шалгалт хийж, 126 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.	Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 5 хяналт шалгалт хийж, 105 дүгнэлт гаргасан.	
2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 360 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100%	Тайлант хугацаанд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 50 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГазарт албан	

				албан бичиг хүргүүлж арилгуулсан.	арилгасан байна.	бичгээр хүргүүлж зөрчлийг 100% арилгуулсан.	
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 16380 бүртгэлд хяналт шалгалт хийж, 24 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.	Эхний хагас жилийн байдлаар нийт 2312 бүртгэлд хяналт шалгалт хийж, 2 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулсан.	
2.3.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;	2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 740 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 17.730.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Тайлант хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 146 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 4.47000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	
2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	-	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	Тайлант хугацаанд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах хүсэлт ирээгүй байна.	

Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	2020 онд архивын стандартын хэрэгжилт 100 хувь хангагдсан.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ЭХЭУБТ-н хадгаламжийн сангийн архивт 15, Иргэний улсын бүртгэлийн хадгаламжийн сангийн архивт-5 ширхэг нягтаршуулсан шүүгээ шинээр нэмж байршуулан архивын стандартын хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллаж байна.	
2.4.2	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх	-	-Тоолсон иргэний баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	2020 оны жилийн эцэст иргэн 165476, хуулийн этгээд 2377, эд хөрөнгийн эрхийн бүртгэл 39198, хувийн баримт архивт хадгалагдаж байна.	Хэлтсийн иргэний баримтын архивыг 100% тоолсон байна.	2021 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний улсын бүртгэл-167921, ЭХЭУБ-40304, Хуулийн этгээдийн улсын бүртгэл- 2490 хувийн хэрэг, баримт хадгалагдаж байна. Архивын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу 4 жилд нэг удаа тооллого явуулна гэж заасны дагуу Иргэний улсын бүртгэлийн хувийн хэргийг 2020 оны 10 дугаар сард төлөвлөгөө	

						гарган тооллогын ажлыг эхлүүлж 2021 оны 05 дугаар сард 100 хувь тоолж дууссан.	
2.4.3	Байгууллагын БНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах	-	-Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх; -Устгасан баримт бичгийн тоо;	-	Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	УБЕГ-н 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 тоот албан бичгийн дагуу 2020 онд хадгалах хугацаа дууссан архивын санд хадгалагдаж байгаа Иргэний гэр бүлийн байдлын хадгаламжийн нэгж, Иргэний улсын бүртгэлийн 29990 хуудас баримт бичгийн устгалын ажлыг хийж, илтгэх хуудас болон устгал хийсэн тухай актыг УБЕГ-н Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлсэн.	
ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
3.1	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг	-	-Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь; -Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	-	Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	ИУБГ-аас 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотоод албан бичгээр ирүүлсэн “МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын	

	хэрэгжүүлж ажиллах, дэд төлөвлөгөө батлах					хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө"-ний хүрээнд хэлтсийн хэмжээнд 30 заалт бүхий дэд төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.	
3.2	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх; -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээг УБЕГ-ын холбогдох газар, хэлтэст сар бүрийн 25-ны дотор гарган хүргүүлж ажиллаж байна.	
ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.							
4.5.1	Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын	-	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.86 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга болон аймгийн Засаг даргаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан	

	гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах		холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;			арга хэмжээний хэрэгжилтийг 100% хангаж ажиллаж байна.	
4.5.2	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд 22 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлан, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2021 онд 17 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлан, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	
4.5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо;	-	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	Тайлант хугацаанд онлайн болон танхимын 14 сургалтанд давхардсан тоогоор нийт 89 албан хаагч хамруулж ажилласан. Мерит төслөөс “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ” цахим сургалтад 26 албан хаагч хамрагдаж сертификаттай төгссөн байна.	
Зорилт 6. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.							
4.6.1	Улсын бүртгэлийн хэлтсийн байртай	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;	-	Төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжсэн	Хэлтэс нь 700мкв талбай бүхий газрыг эзэмшиж	

	болох асуудлаар холбогдох арга хэмжээг авах				байна.	байна. 2020 онд ажлын байрны аюулгүй байдлын дүгнэлт, дулааны шугамд холбох техникийн нөхцөл, цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл, шилэн кабель, телефон сүлжээнд холбох техникийн нөхцлүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар гаргуулан бэлтгэл ажлыг хангаж байна. Барилгын төсвийг 2021 оны байгууллагын төсөвт тусгасан боловч батлагдаагүй. 2022 оны улсын төсөвт санхүүжилтийг тусгах асуудлаар ХЗДХЯ болон УБЕГ-ын удирдлагуудад санал хүргүүлсэн.	
4.6.2	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; -Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал;	2020 онд тус хэлтэст нийт 1143 өргөдөл гомдол ирснийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	2021 онд тус хэлтэст нийт 128 өргөдөл гомдол ирснийг 100% шийдвэрлэж, тайланг УБЕГазар болон аймгийн ЗДТГазарт хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцорсон өргөдөл,	

				шийдвэрлэлт 100 хувьтай байна.		гомдол байхгүй.	
4.6.3	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 737 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 351 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай.	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна.	2021 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст нийт 390 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 198 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай.	
4.6.4	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	Хэрэгжилт 100 хувь	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна.	Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчтай холбоотойгоор төрийн албан хаагчийн ёс зүй хэм хэмжээг зөрчсөн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна. Төрийн албан хаагчдын манлайлал, үйлчилгээний стандарт, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 26 алба албан хаагчийг хамрууллаа. Үйлчилгээний	

						стандартын хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна.	
4.6.5	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх;	2020 онд ардын уламжлалт бариа заслын эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	“Итгэлт-Ивээл” эмнэлэгтэй хамтран хэлтсийн 20 албан хаагчдын 0-12 насны 24 хүүхдэд витамин Д шинжилгээг үнэ төлбөргүй хийлгэсэн. Албан хаагчдыг 3 дугаар улиралд урьдчилсан шинжилгээнд хамруулахаар төлөвлөөд байна. Ковид-19 цар тахлаас сэргийлэх вакцинд хамрагдах хэлтсийн нийт албан хаагчдын судалгааг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эрүүл мэндийн газарт хүргүүлж албан хаагчид вакцинд 100% хамруулсан.	
4.6.6	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь;	2020 онд 3 удаагийн даргын зөвлөлийн, 8 шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулсан ба нэгжүүдэд 6 үүрэг даалгавар	Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг, даалгаврууд бүрэн хэрэгжсэн байна.	2021 онд 2 удаагийн даргын зөвлөлийн, 6 шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулсан ба тасаг нэгжүүдэд 8 үүрэг даалгавар өгөгдсөний	

				өгөгдсөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.		хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	
4.6.7	Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх	-	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх;	2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын 39 тушаал, 18 үүрэг даалгавар ирсэн.	Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дарааллаар нарийн хөтөлсөн байна. Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	2021 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст УБЕГ-ын даргын 14 тушаал, 13 чиглэл, 1 үүрэг даалгавар ирсэн. Тушаал, үүрэг даалгаварын хэрэгжилтийг 100% хангаж ажилласан.	
4.6.8	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой 1 албан бичиг ирсэн.	Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Тайлант хугацаанд эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинээр гарган батлав. Нууц хамгаалах ажилтанд шаардлагатай суурин компьютерыг шинэчилэн байршуулав. Мөн нууц хамгаалах ажилтны өрөөг холбогдох хуульд заасны дагуу тохижуулахаар шаардлагатай төсвийг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлээд байна.	
4.6.9	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн	2020 онд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд 12 удаа	Сар бүр мэдээлэл байршуулсан байна.	Тайлант хугацаанд www.dornod.burtgel.gov.mn вэб	

	мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх		үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	байршуулсан.		www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудсанд иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн 5 удаа байршуулсан.	
4.6.10	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал;	1	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр хянагдаж байгаа 1 хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ЭХЭУБТасгийн дарга Ж.Ганзориг томилогдон оролцож байна. Хэрэг маргааны судалгааг холбогдох газарт хүргүүлсэн.	
4.6.11	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн	-	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим	2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахим	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж	Тайлант хугацаанд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг	

	хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох		хуудаст байршуулсан тоо; -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо;	болон фэйсбүүк хуудсанд 233 удаа байршуулсан. Орон нутгийн телевиз, сонинд 4 удаа мэдээлэл хийсэн.	хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна.	www.dornod.burtgel.gov.mn цахим хуудсанд 69 удаа байршуулсан. Орон нутгийн МИЖИ телевизээр “Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл зогсоох тухай” мэдээлэл хийсэн.
4.6.12	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	2020 онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 4 удаа зохион байгуулсан.	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 5-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	Коронавирус /ковид-19/ цар тахлын хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор иргэдийг өөрийн биеэр ирэлгүйгээр гэрээсээ байгууллагын нээлттэй утас 98-970-970, www.dornod.burtgel.gov.mn вэб, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудас руу хандан зөвлөгөө мэдээлэл авах боломжийг бүрдүүлж ажилласан.
4.6.13	Иргэдийн санал хүсэлтийг сонсох 98-970-970 утасны үйлчилгээний чанар	-	-Утсаар лавлагаа мэдээлэл авсан тоо;	Хэлтсийн лавлах 98-970-907 утсанд 917 иргэн утсаар холбогдсон, тухай	Улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэсэн	Хэлтсийн лавлах 98-970-970 утсанд 583 иргэн утсаар холбогдож, тухай бүр шийдвэрлэсэн.

	хүртээмжийг сайжруулах			бүр шийдвэрлэсэн.	байна.	Хэлтсийн 98-970-970 тусгай дугаарын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын мэдээллийн самбар, www.dornod.burtgel.gov.mn цахим сайт, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол сурталчилж ажиллаж байна.	
--	------------------------	--	--	-------------------	--------	---	--

Зорилт 7. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.

4.7.1	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах		Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх;	2020 онд Гэрлэх ёслолын өргөө болон буланг байгуулах 46.673.350 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.	Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.	Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх зорилгоор “Гэрэгэ КИОСК” машины төсвийг орон нутгийн төсөвт тусгуулах саналыг Аймгийн ЗДТГазарт хүргүүлсэн.	
-------	--	--	----------------------------------	---	---	--	--

Зорилт 8. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

4.8.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн	Батла	-Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын	2020 онд 399.141.700 төгрөгийн урсгал	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой,	Тайлант хугацаанд 225.701.900 төгрөгийн урсгал төсөвтэй үйл	
-------	---	-------	---	---------------------------------------	--	---	--

	удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах	гдсан төсөв	шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	төсвөөс 387.875.300 сая төгрөгийг зарцуулсан. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас “ИТГЭМЖЛЭЛ” дүгнэлттэй үнэлэгдсэн болно	хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.	ажиллагаа явуулж гүйцэтгэл 81.4 хувьтай байна. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас “ЗӨРЧИЛГҮЙ” дүгнэлттэй үнэлэгдсэн.	
4.8.2	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах	-	-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх; -Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх; -Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;	2020 онд Хэлтсийн бараа материалын хангалтыг УБЕГ-ын Санхүү төлөвлөлийн газраас нийт 17.139.088,5 төгрөгийн бараа материалын татан авалт хийж, 1.638.846 төгрөгийн өртөг бүхий 1 зөөврийн компьютерийг балансаар шилжүүлэн авч ажиллав. Үнэт цаас, гэрчилгээ, маягтуудын нөөц	Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын	2021 оны эхний хагас жилийн байдлаар Хэлтсийн бараа материалын хангалтыг УБЕГ-ын Санхүү төлөвлөлийн газраас нийт 8.233.500 төгрөгийн бараа материалын татан авалт хийж, 5.725.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаар шилжүүлэн авч ажиллав. Үнэт цаас, гэрчилгээ, маягтуудын нөөц бүрдүүлснээр бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн, тасалдалгүй явагдах нөхцлөөр бүрэн хангаж	

				бүрдүүлснээр бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн, тасалдалгүй явагдах нөхцлөөр бүрэн хангаж ажилласан.	Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.	ажилласан.	
4.8.3	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	-	-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	2020 онд Шилэн дансны цахим сайтад 139 мэдээлэл оруулахаас 139 хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл 2 байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Тайлант хугацаанд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг www.shilendans.gov.mn , цахим сайтад 63 мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.	
4.8.4	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах	-	-Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах; -Хүчингүй болсон үнэт цаас, тамга тэмдгийг журмын дагуу устгах; -Төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогод бэлтгэх; -Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх;	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэргээр 2 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна.	Тайлант хугацаанд А/07 дугаар тушаалаар байгууллагын мөнгөн хөрөнгө, бараа материалын тооллогыг явуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны зарцуулалт,	

			-Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай болох; -Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргах; -Тайланг 2 удаа хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах;			үндсэн хөрөнгийг бүртгэх талаар 2 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.	
--	--	--	---	--	--	---	--

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Д.ОЮУНБАЯР/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)